

Батлав:

Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны дарга



Д.Мөнхбат

Батлав: ОВНГОГОВ АЙМАГ

“Тавантолгой” ХК-ийн
захирал

TAVANTOLGOI LLC

Гүйцэтгэх

Р.Сэддорж



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2017 оны 07-дөрөн 11 сарын

Дугаар 04

Сайншианд хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7; 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу “Монгол – Ус” ТӨҮГ-аас гаргасан 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 16 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргааны даргын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн A/03 тоот тушаалыг тус тус үндэслэн:

Ус ашиглуулагч /цаашид “Захиргаа” гэх-/ийг төлөөлж Галба-Өөш Долоодын говийн сав газрын захиргааны усны үнэ тариф, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Пүрэвдорж нөгөө талаас ус ашиглагч /цаашид “Ус ашиглагч” гэх-/ийг төлөөлж Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо баг, “Тавантолгой” ХК /улсын бүртгэлийн дугаар 1110001005, регистрийн дугаар 2016656/-ийн Усны менежер З.Наранзаяа нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:

- 2.1.1. Үнд, ахуй
- 2.1.2. Уурхайн зам талбайн усалгаа, тоосжилт дараад
- 2.1.3. Биологийн нөхөн сэргээлт
- 2.1.4. Уурхайн ухлагын үед гарсан шүүрлийн усыг шавхан зайлцуулах

2.2. Ашиглах усны хэмжээ:

- 2.2.1. Үнд ахуйн усны хэрэглээ 9.240 м³/жил
- 2.2.2. Биологийн нөхөн сэргээлтэд 760 м³/жил
- 2.2.3. Уурхайн зам талбайн усалгаа, тоосжилт дараад ашиглах ус 28.800 м³/жил
- 2.2.4. Уурхайн ухлагаас шавхан зайлцуулах ус 1.486.800 м³/жил

2.3. Усны эх үүсвэрийн:

2.3.1. Байршил: Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Улаан нуураас 4-5 км, сумын төвөөс 12 км –т байрладаг.

| | | |
|--------------------------------|------------|-----------|
| 2.3.2. 1-р худаг /Тавантолгой/ | 105°25'26" | 43°40'1" |
| 2-р худаг /Улаан худаг/ | 105°26'32" | 43°40'1" |
| 3-р худаг /Өндөрийн сан/ | 105°26'24" | 43°39'58" |
| 4-р худаг /Маалийн худаг/ | 105°25'26" | 43°39'50" |

2.4.3. Тоног төхөөрөмжийн нэр, марк, хүчин чадал:

- Уурхайгаас шүүрсэн усыг шавхан зайлцуулах WQ 70-20 маркын насос ашигладаг.

2.5. Ус ашигласны төлбөрийн хэмжээ:

2.5.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1. дэх заалтын дагуу унд ахуйд ашиглах 9.240 м^3 , 20.1.3 дахь заалтын дагуу уурхайн зам талбайн усалгаа, тоосжилт дараад ашиглах 28.800 м^3 усыг (шавхан зайлцуулах уснаас эргүүлэн ашиглана) тус тус төлбөрөөс чөлөөлнө.

2.5.2. Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны төлбөр: $760 \text{ м}^3 \times 71,928 \text{ төг} = 54,665 \text{ төг}$ /Тавин дөрвөн мянга зургаан зуун жаран тав/

2.5.3. Уурхайн ухлагаас шавхан зайлцуулах усны төлбөр: $1.486.800 \text{ м}^3 \times 719,28 \text{ төг} = 1.069.425.504 \text{ төг}$ /Нэг тэр бум жаран есөн сая дөрвөн зуун хорин таван мянга таван зуун дөрөв/

2.5.4. Дээрх усны нөөц ашигласан төлбөрийг Өмнөговь аймгийн төсөвт буюу төрийн сан банкин дахь 110000944 тоот дансанд төвлөрүүлнэ.

2.5.5. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 23.2.-т заасны дагуу төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 сарын 10-ны өдрийн дотор харьялагдах татварын албанад тушааж эцсийн байдлаар тооцоо хийнэ.

Гурав. Талуудын эрх, үүрэг

- 3.1. Гэрээ байгуулагч талууд Усны тухай хуулийн 7.5; 10.1.18; 13.1.1; 13.1.5; 18.1.4; 19.1.2; 19.1.4; 26.1; 30.1; 30.2; 31.1; 33.1.14 -т заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 3.2. Гэрээний хоёр талт зорилтыг хангах зорилгоор Захиргаа ба Ус ашиглагч нь гэрээний заалтуудыг хэрэгжүүлэх бүх арга хэмжээг авч хамтран ажиллана.

Дөрөв. Бусад

- 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салашгүй хэсэг байна.
- 4.3. Энэхүү гэрээний дагуу төлсөн төлбөрийн талаарх жилийн тайланг 2018 оны 01 сарын 10-ны дотор Захиргаанд хүргүүлэх бөгөөд талууд 2018 оны 01 дүгээр сард багтаан гэрээний хэрэгжилтийг дүгнэнэ.
- 4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
 - 4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
 - 4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол;
- 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захирагааны усны үнэ тариф, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

/С.Пүрэвдорж/

Хаяг: Дорноговь, Сайншанд хот, Шанти буйлдинг 2 давхар

Харилцах утас: (976) -70523682, 88019841

Ус ашиглагчийг төлөөлж:

“Тавантолгой” ХК-ийн Усны менежер

/З.Наранзаяа/

Хаяг: Өмнөговь аймаг, Цогтцэций сум,
Цагаан-овоо баг

Харилцах утас: (976) -70532550, 94001619,
88068970